



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД Н.ЦЭРЭНБАТ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2016. 10. 02 № 40

Асуулга тавих тухай

Миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13-т заасан бүрэн эрхийнхээ дагуу дараах асуулгын Танд тавьж байна:

Улсын Их Хурлын 2011 оны 18 дугаар тогтоолоор Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Баянзүрх сумын нутгийн зарим хэсгийг хамруулан Улаан тайгын дархан цаазат газар, Цагааннуур, Рэнчинлхүмбэ, Улаан-Уул сумын нутаг дэвсгэрийн зарим хэсгийг хамруулан Тэнгис-Шишгэдийн голын ай савын байгалийн цогцолборт газар, Алаг-Эрдэнэ, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Ханх сумын нутаг дэвсгэрийн зарим хэсгийг хамруулан Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын хилийн цэсийг тогтоон тус тус тусгай хамгаалалттай газар нутагт авсан.

Байгалийн унаган төрхөөрөө нүд баясгаж, сэтгэл сэргээсэн хөвч тайга, цэнгэг уст нуур, гол, байгалийн өвөрмөц тогтоц, эрүүл цэнгэг агаараараа аялагчдын сэтгэлийг татдаг үзэсгэлэнт Хөвсгөл аймгийн дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт ирэх жуулчдын тоо жил тутам өсч байгаатай холбогдуулан аялал жуулчлалын баазууд болон гэр буудлуудын тоо, тэдгээрийн үйл ажиллагаа хамрах газар нутгийн хэмжээ улам бүр тэлж байна.

Хэдийгээр төрөөс эдгээр газар нутгийг аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэхээр төлөвлөсөн нь зүйтэй боловч нутаг орны ашиг сонирхол, оршин суугч иргэдийн эрх ашиг зөрчигдөж байгааг анхаарахгүй орхиж, үл тоомсорлож болохгүй юм.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэрийг хамгаалалтын захиргаа болон сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн гаргадаг.

Хэдийгээр газар ашиглуулах шийдвэрийг сумын Засаг даргын саналыг үндэслэн гаргахаар хуульд заасан боловч хуулийн энэ заалт хэрэгжихгүй, сум, тосгоны удирдлага, оршин суугч иргэн өөрөө мэдээгүй байхад тэдний олон үеэрээ амьдарч, ашиглаж ирсэн бэлчээр, өвөлжөө, хаваржааны газар нутаг дээр давхцуулан аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдэд газар эзэмших гэрчилгээ олгосон талаар гомдол гарч байна. Тухайлбал, Хатгал тосгоны хувьд 117 иргэн, компанид газар эзэмших гэрчилгээ олгосноос Хөвсгөл аймгийн харьяалалтай 36 иргэн, аж ахуйн нэгж байна.

0000000110

Нөгөөтэйгүүр дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын дэглэм, хамгаалалтын горимоос шалтгаалан тус бүс нутагт явуулж болох үйл ажиллагаа нь хязгаарлагдмал байдгаас тэнд амьдардаг иргэдийн хувьд олон үйл ажиллагаа хориглогдсон байдаг.

Ялангуяа хөдөө орон нутагт амьдарч байгаа иргэдийн хувьд газар бол тэдний оршин байх үндсэн нөхцөл бөгөөд энэ талаар эдгээр тусгай хамгаалалттай бүс нутагт амьдарч буй иргэдээс байнга гомдол, санал гаргаж байдаг хэдий ч төрийн аль ч шатны байгууллагад шийдэгдэхгүй, иргэд хохирсоор, цаашдаа хэвийн ажиллаж, амьдрах нөхцөлгүй болж байна.

Иймд миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13-т заасан бүрэн эрхийнхээ дагуу дараах асуулгыг Танд тавьж байна:

1/Хөвсгөлийн байгалийн цогцолборт газарт ямар нөхцөл, шаардлага, журмын дагуу, хэрхэн газар ашиглах эрх олгож байгаа талаар;

2/Хөвсгөлийн байгалийн цогцолборт газарт хамаарах Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон, Ханх сумын нутаг дэвсгэрт тус яамнаас олгосон одоо хүчин төгөлдөр байгаа газар ашиглуулах эрх, хилийн зааг, газар ашиглуулах эрх дуусах хугацаатай холбоотой судалгаа;

3/Газар ашиглах эрхтэй холбоотойгоор болон тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж, амьдрахтай холбоотой асуудлаар орон нутгийн иргэдээс ирүүлсэн санал, гомдол, өргөдөл, хүсэлтүүд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаар;

4/Байгалийн цогцолборт газарт газар ашиглах эрх олгохдоо нутгийн ард иргэдийн саналыг авах, эрх ашиг нь хөндөгдөж болзошгүй иргэдтэй санал солилцох, сонсгол хийх зэргээр Захиргааны ерөнхий хуульд заасан зарчмыг баримтлан шийдвэрээ гаргах талаар авч байгаа арга хэмжээний тухай;

5/Байгалийн цогцолборт газарт газар ашиглах эрх авсан аж ахуйн нэгж, иргэд холбогдох хууль тогтоомж, гэрээнд заасны дагуу үйл ажиллагаагаа явуулж буй эсэх болон түүнд тавьж байгаа хяналтын талаар;


6/Цаашид Хөвсгөл аймаг дахь байгалийн цогцолборт болон дархан цаазат газрын талаар хэрэгжүүлэх арга хэмжээ, төлөвлөсөн ажлын талаар;

7/Хөвсгөл аймаг дахь байгалийн цогцолборт болон дархан газрын дэглэм, горимыг тухайн нутагт ажиллаж, амьдардаг иргэдийн хувьд илүү уян хатан болгох талаар ямар арга хэмжээ авах талаар.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Л.МӨНХБААТАР